

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/15/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Нурлан
Утас: 88403281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА К.БОЛАТ ТАНАА
<u>2023.02.24</u> № <u>175</u> танай _____-ны № _____-т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Тус газрын 2022 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч байгууллагын даргаар батлуулаагүй байна.</p>	
Бусад асуудлын хэсэг	
<p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32,760,678.50</u>	<u>66,208,093.70</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	33,598,496.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	33,598,496.00
3121	Төгрөг	-	33,598,496.00
31211	Төрийн сангийн харилцах	-	33,598,496.00
33	АВЛАГА	1,468,050.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	146,700.00	-
335	Бусад авлага	1,321,350.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,321,350.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	31,292,628.50	32,609,597.70
351	Түүхий эд материал	4,561,166.70	6,507,786.70
35110	Тусгай зориулалттай материал	4,501,166.70	6,447,786.70
35130	Эм боох материал	60,000.00	60,000.00
354	Хангамжийн материал	26,731,461.80	26,101,811.00
35410	Бичиг хэргийн материал	4,039,300.00	3,527,500.00
35420	Аж ахуйн материал	11,176,721.00	9,908,121.00
35440	Түлш, шатах тослох материал	40.80	-
35450	Барилгын засварын материал	216,000.00	596,000.00
35470	Бусад хангамжийн материал	11,299,400.00	12,070,190.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,300,652,589.87</u>	<u>1,498,485,273.23</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,300,652,589.87	1,498,485,273.23
392	Биет хөрөнгө	1,286,361,789.87	1,477,666,073.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,125,123,694.00	1,127,486,694.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(40,629,118.80)	(59,381,180.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	102,236,750.00	49,745,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(85,508,347.21)	(6,307,430.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	363,664,323.79	418,190,011.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	(225,527,733.60)	(116,873,667.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,493,145.00	80,905,845.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,816,558.20)	(19,932,533.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,833,200.00	4,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(507,565.11)	(166,666.67)
393	Биет бус хөрөнгө	14,290,800.00	20,819,200.00
39301	Програм хангамж	2,458,000.00	3,958,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,087,200.00)	(298,800.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,920,000.00	17,160,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,333,413,268.37</u>	<u>1,564,693,366.93</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,333,413,268.37</u>	<u>1,564,693,366.93</u>

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51	Засгийн газрын хувь оролцоо	1,333,413,268.37	1,564,693,366.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	109,782,696.79	109,782,696.79
51101	Өмч: - төрийн	109,782,696.79	109,782,696.79
512	Хуримтлагдсан үр дүн	1,222,946,449.36	1,454,696,939.41
51210	Өмнөх үеийн үр дүн	1,222,946,449.36	1,223,416,840.85
51220	Тайлант үеийн үр дүн	-	231,280,098.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	684,122.22	213,730.73
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,333,413,268.37	1,564,693,366.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	730,882,125.85	1,147,156,264.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	128,887,686.37	447,069,141.86
120	Нийтлэг татварын бус орлого	128,887,686.37	447,069,141.86
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	128,887,686.37	447,069,141.86
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,497,905.00	247,172,987.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,389,781.37	199,896,154.86
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	601,994,439.48	700,087,123.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	437,837,100.00	481,561,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	481,561,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	437,837,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	126,342,739.48	215,045,623.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	126,342,739.48	215,045,623.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,836,600.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,836,600.00	-
1330	Төсвийн захирагчдаас	6,978,000.00	3,479,800.00
133003	Хөрөнгийн	6,978,000.00	3,479,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	682,090,209.27	911,653,309.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	682,090,209.27	911,653,309.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	547,144,841.47	586,147,096.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,609,626.99	362,900,885.84
210101	Үндсэн цалин	349,877,026.99	362,900,885.84
210105	Гэрээт ажлын хөлс	732,600.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,906,543.69	45,504,763.44
210201	Тэтгэврийн даатгал	44,906,543.69	45,504,763.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,365,755.20	36,998,758.80
210301	Гэрэл, цахилгаан	2,002,570.00	2,312,500.00

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	28,806,385.20	33,129,858.80
210303	Цэвэр, бохир ус	1,556,800.00	1,556,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,795,819.34	33,620,360.80
210401	Бичиг хэрэг	4,606,150.00	7,754,950.00
210402	Тээвэр, шатахуун	10,892,669.34	20,351,840.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	259,750.00	375,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	180,050.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	12,037,250.00	4,957,970.00
2105	Нормативт зардал	280,200.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	280,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	286,000.00	-
210604	Урсгал засвар	286,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	13,587,000.00	22,014,700.00
210702	Дотоод албан томилолт	13,587,000.00	22,014,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,812,436.00	227,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	32,600.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	146,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,736.00	80,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,747,100.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,501,460.25	84,880,227.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,155,120.00	11,642,389.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,346,340.25	73,237,838.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,945,367.80	325,506,213.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	39,161,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	39,161,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	60,907.11	72,770,122.73
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	60,907.11	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	179,300.00
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг-нэмэлт	-	72,590,822.73
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,386,555.69	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,386,555.69	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	120,497,905.00	213,574,491.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,497,905.00	213,574,491.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	48,791,916.58	235,502,955.12
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	26,400.00	4,222,856.56
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	26,400.00	2,689,676.56
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,533,180.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(26,400.00)	(4,222,856.56)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	48,765,516.58	231,280,098.56

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>715,514,344.48</u>	<u>943,780,310.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,497,905.00	247,172,987.00
120	Нийтлэг татварын бус орлого	120,497,905.00	247,172,987.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	120,497,905.00	247,172,987.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,497,905.00	247,172,987.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	595,016,439.48	696,607,323.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	437,837,100.00	481,561,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		481,561,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	437,837,100.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	126,342,739.48	215,045,623.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	126,342,739.48	215,045,623.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,836,600.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,836,600.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>622,654,144.48</u>	<u>836,317,770.81</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	622,654,144.48	836,317,770.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	485,774,471.55	509,006,057.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	338,306,949.46	347,586,317.20
210101	Үндсэн цалин	228,768,495.33	278,001,279.11
210102	Нэмэгдэл	86,529,564.20	59,580,217.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,563,000.00	8,433,000.00
210104	Урамшуулал		1,571,820.60
210105	Гэрээт ажлын хөлс	15,445,889.93	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,958,267.09	41,842,779.08
210201	Тэтгэврийн даатгал	44,883,522.31	30,277,479.08
210202	Тэтгэмжийн даатгал	274,337.29	2,891,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	219,469.77	2,313,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	52,812.51	578,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	528,125.21	5,782,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,550,500.00	36,998,758.80
210301	Гэрэл, цахилгаан	2,002,570.00	2,312,500.00
210302	Түлш, халаалт	26,991,130.00	33,129,858.80
210303	Цэвэр, бохир ус	1,556,800.00	1,556,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,849,250.00	20,156,600.00

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	4,610,800.00	5,396,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,568,350.00	13,538,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	377,600.00	302,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	292,500.00	919,300.00
2105	Нормативт зардал	343,200.00	275,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	343,200.00	275,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	286,000.00	185,100.00
210604	Урсгал засвар	286,000.00	185,100.00
2107	Томилолт, зочны зардал	14,415,000.00	23,171,829.00
210702	Дотоод албан томилолт	14,415,000.00	23,171,829.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	212,036.00	80,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	32,600.00	
210803	Даатгалын үйлчилгээ	146,700.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,736.00	80,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,853,269.00	38,708,773.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,853,269.00	38,708,773.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,879,672.93	327,311,713.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,934,305.13	40,967,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,934,305.13	1,805,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		39,161,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	60,907.11	72,770,122.73
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	60,907.11	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		179,300.00
213305	Төвлөрүүлэг шилжүүлэг-нэмэлт		72,590,822.73
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,386,555.69	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,386,555.69	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	120,497,905.00	213,574,491.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,497,905.00	213,574,491.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	92,860,200.00	107,462,539.19
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	92,860,200.00	73,864,043.19
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,860,200.00	73,864,043.19
2200	Дотоод эх үүсвэрээр	92,860,200.00	73,864,043.19
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	92,860,200.00	73,864,043.19
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(92,860,200.00)	(73,864,043.19)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	33,598,496.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	33,598,496.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	109,782,696.79	684,122.22	1,222,946,449.36	1,333,413,268.37
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,782,696.79	684,122.22	1,222,946,449.36	1,333,413,268.37
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,782,696.79	684,122.22	1,222,946,449.36	1,333,413,268.37
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	109,782,696.79	684,122.22	1,222,946,449.36	1,333,413,268.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			470,391.49	470,391.49
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,782,696.79	684,122.22	1,223,416,840.85	1,333,883,659.86
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-470,391.49		-470,391.49
D08	Тайлант үеийн үр дүн			231,280,098.56	231,280,098.56
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,782,696.79	213,730.73	1,454,696,939.41	1,564,693,366.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	481,561,700.00	481,382,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	481,561,700.00	481,382,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,594,600.00	440,415,300.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	335,005,800.00	335,005,800.00
210101	Үндсэн цалин	270,837,100.00	265,420,761.91
210102	Нэмэгдэл	54,991,300.00	59,580,217.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,177,400.00	8,433,000.00
210104	Урамшуулал	00.00	1,571,820.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,248,400.00	41,248,400.00
210201	Тэтгэврийн даатгал	29,683,100.00	29,683,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,891,300.00	2,891,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,313,100.00	2,313,100.00

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	578,300.00	578,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,782,600.00	5,782,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,081,100.00	27,081,100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,004,000.00	2,312,500.00
210302	Түлш, халаалт	23,212,200.00	23,212,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,864,900.00	1,556,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,152,200.00	9,152,200.00
210401	Бичиг хэрэг	1,586,500.00	1,586,500.00
210402	Тээвэр, шатахуун	6,343,700.00	6,343,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	302,700.00	302,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	919,300.00	919,300.00
2105	Нормативт зардал	275,200.00	275,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	275,200.00	275,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	185,100.00	185,100.00
210604	Урсгал засвар	185,100.00	185,100.00
2107	Томилолт, зочны зардал	4,428,500.00	4,428,500.00
210702	Дотоод албан томилолт	4,428,500.00	4,428,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	260,000.00	80,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	32,600.00	
210803	Даатгалын үйлчилгээ	146,700.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,700.00	80,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22958300.00	22958300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,958,300.00	22,958,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40967100.00	40967100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,967,100.00	40,967,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,805,500.00	1,805,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,161,600.00	39,161,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	481,561,700.00	481,382,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	481,561,700.00	481,382,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	481,561,700.00	481,382,400.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Гүйцэтгэл	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	142,454,800.27	215,045,623.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	127,848,257.08	127,848,257.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,848,257.08	127,848,257.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,181,385.00	12,580,517.20
210101	Үндсэн цалин	12,181,385.00	12,580,517.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	993,511.28	594,379.08

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	993,511.28	594,379.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,917,658.80	9,917,658.80
210302	Түлш, халаалт	9,917,658.80	9,917,658.80
2104	Хангамж, бараа материалын зардал	11,004,400.00	11,004,400.00
210401	Бичиг хэрэг	3,810,000.00	3,810,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,194,400.00	7,194,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,769,000.00	12,769,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	769,000.00	769,000.00
210602	Тавилга	12,000,000.00	12,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	18,743,329.00	18,743,329.00
210702	Дотоод албан томилолт	18,743,329.00	18,743,329.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62238973.00	62238973.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,238,973.00	62,238,973.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	72590822.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	72,590,822.73
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	72,590,822.73
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,606,543.19	14,606,543.19
2200	Дотоод эх үүсвэрээр	14,606,543.19	14,606,543.19
222001	Тоног төхөөрөмж	14,606,543.19	14,606,543.19
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	215045623.00	215045623.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	215,045,623.00	215,045,623.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	215,045,623.00	215,045,623.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь Газар зохион байгуулалт, газрын кадастр, геодези, зураг зүй, барилга, хот байгуулалтын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангах, таатай нөхцөлд амьдрах, ажиллах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, чиг үүргийг хэрэгжүүлэхээр зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 13 зорилгын хүрээнд 116 арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 13 зорилгын 116 арга хэмжээг аймгийн аймгийн Засаг даргын тамгын газрын дарга 99.02 хувиар үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Газрын кадастрын мэдээллийн санг ажиллуулах журам болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд боловсруулсан боловч байгууллагын даргын тушаалаар батлуулаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 231.3 сая төгрөгөөр буюу 17.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		33,598.5	33,598.5
Авлага	1,468.0		1,468.0
Бараа материал	31,292.6	32,609.6	1,317.0
Үндсэн хөрөнгө	1,300,652.6	1,498,485.3	197,832.7
Нийт хөрөнгө	1,333,413.3	1,564,693.4	231,280.1
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,333,413.3	1,564,693.4	231,280.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,333,413.3	1,564,693.4	231,280.1

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө 33.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь жилийн эцэст төвлөрүүлээгүй газрын орлогын үлдэгдэл байна.

Авлагын үлдэгдэл 1.5 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны тээвэр шатахуун, шуудан холбооны авлага байна.

Бараа материалын данс 1.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 197.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хандиваар 10.5 сая төгрөгийн, 186.5 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлж, төсвийн хөрөнгөөр 73.8 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 9.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж, үндсэн хөрөнгөд 73.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 231.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 548.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 548.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас улсын төсвийн цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 46.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 10.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6.6 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 17.8 сая төгрөгөөр, нормативт зардал 1.5 сая төгрөгөөр, томилолт, зочны зардал 9.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 0.5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 15.0 сая төгрөгөөр хасаж, эд хогшил, урсгал засварын зардал 0.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 481.5 сая төгрөгөөр баталсан баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд 494.1 сая төгрөгийн төсөв батлагдаж төсвийг 12.6 сая төгрөгөөр бууруулан тодотгож төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 481.5 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 481.5 сая төгрөгийг санхүүжилтийг хүлээн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 481.4 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 0.2 сая төгрөгөөр дутуу зарцуулж жилийн эцэст 0.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд газрын орлогоос 247.2 сая төгрөгөөр бүрдүүлж, 213.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 33.6 сая төгрөг дансанд үлдсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	100020029001- Үндсэн данс	481,561.7	481,382.4	179.3	99,9%
1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	417,636.3	417,457.0	179.3	99.9%
1.2	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	40,967,1	40,967.1	0	100%
1.3	Барилгын техник хяналт	22,958.3	22,958.3	0	100%
	Дүн	481,561.7	481,382.4	179.3	99,9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2022 онд 215.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Үүнээс 127.8 сая төгрөгийг зарцуулж 72.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 45 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 682.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох, даатгалын үйлчилгээ зардлыг 0.2 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан ба бусад зардлыг хэмнэж ажиллаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй ба илэрсэн алдаа, зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 131.7 сая төгрөгийн 44 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75% байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын дүнгээр шилэн дансны зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааг явуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр хийсэн ба алдаа зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, албан шаардлага өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 259.0 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 131.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 127.3 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчилд албан шаардлага өгөв. Үүнд:

1. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 131.7 сая төгрөгийн 44 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75% байгаа зөрчилд албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. 1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Халаалтын төлбөр, цахилгааны төлбөр, цэвэр бохир усны төлбөр, албан томилолт, шуудан холбооны зардлаас нийт 59.7 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 20.2, 20.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж аливаа гүйлгээг тооцооны данс дамжуулан бүртгэж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

“Бек-импекс” ХХК-аас 0.8 сая төгрөгийн, “Инженер Геодези” ХХК-аас 28.6 сая төгрөгийн, иргэн К.Ерболатаас 0.6 сая төгрөгийн, “Эрхэт инноваци” ХХК-аас 19.5 сая төгрөгийн, “Гео инструмент” ХХК-аас 1.8 сая төгрөгийн, “Юби ХХК”-аас 1.0 сая төгрөгийн нийт 52.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, “Говь-Хангай мебель” 1.5 сая төгрөгийн, “Ворлд меракл” ХХК-аас 13.8 сая төгрөгийн нийт 15.2 сая төгрөгийн тавилга, аж ахуйн эд хогшил бүгд 67.6 сая төгрөгийн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авч төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.1 Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно”, 14.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шууд зардлаар бүртгэж тайлагнасан	1	59,716.9					1	59,716.9				
Дүн	1	59,716.9					1	59,716.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 131.7 сая төгрөгийн 44 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй	1	131,716.7			1	131,716.7		
Дүн	1	131,716.7			1	131,716.7		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт 67.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авахдаа төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлээгүй	1	67,619.5					1	67,619.5
Дүн	1	67,619.5					1	67,619.5
Нийт дүн	2	199,335.7			1	131,716.7	1	67,619.5